

**БЯМБЫН РИНЧЕНИЙ “ҮҮРИЙН ТУЯА” РОМАН ДАХЬ ДЭД
БҮТЭЭВЭР, ТҮҮНИЙ НАЙРУУЛГЫН ҮҮРЭГ**

М.Энхжаргал
/МУБИС/

Түлхүүр үг: бүтээвэр зүй, монгол хэл, үгийн утга, роман

Товч агуулга:

Орчин цагийн монгол хэлэнд үг бүтэх олон арга байдаг бөгөөд үндсэн аргын нэг нь “Дагаврын аргаар үг бүтэх ёс” юм. Энэ нь үгийн язгуур үндсэнд үг бүтээх дагавар залгаж шинэ үг бүтэх аргыг хэлдэг. Гэтэл хэлний энэ зүй тогтлыг зөрчиж, тухайн язгуур үндсэнд дагавар нэмэн залгавч шинэ утга бүхий үг бүтээхгүй байгаа сонирхолтой үзэгдэл ажиглагдаж байна. Үг зүй буюу бүтээврийн түвшинд үүнийг субморф (дэд бүтээвэр) хэмээн нэрлэдэг.

Уг өгүүлэлд Б.Ринчений “Үүрийн туяа” роман дахь дэд бүтээврийн илрэх хэлбэр, хэмжээ, найруулгын үүргийг жишээ баримтаар баяжуулан тайлбарлахыг оролдсон болно.

1. Дэд бүтээврийн тухай

Хэл шинжлэлд дэд аялгуу, дэд өргөлт, дэд утга гэх зэрэг олон ойлголт байдгийн нэг нь энэхүү бидний авч үзэж байгаа “дэд бүтээвэр” хэмээх ойлголт юм. Субморф буюу дэд бүтээвэр нь хэлний бүтээврийн түвшний дэд нэгж бөгөөд тухайн үндэснээ дэд бүтээврийг нэмж залгавч утга төдий л нэмэгдэхгүй, зөвхөн үл ялих найруулга, хэрэглээний ялгаа бий болгож буй хэсэг бүлэг бүтээврийг хэлнэ. Энэхүү бүтээврийн түвшинд илрэх дэд нэгжийг нэрлэсэн нэршил нь янз бүр байна. Үүнд: Е.А.Земская, Е.С. Кубрякова “дэд бүтээвэр” (субморф), Н.М.Шанский “залгаваранцар”(аффиксоиды), Д.С. Ворт “утгын агуулгагүй бүтээвэр”(не семантическое содержание морфем), В.В. Лопатин “жийрэг, илүүдэл маягийн бүтээвэр” (“избыточные” с формальной морфем), Г.О. Винокур “үндсийн хувилбар” (передюю вариацию)-г үүсгэж байгаа бүтээвэр”, А.И. Моисеев “хуурмаг бүтээвэр” (квазиморфема) гэж тус тус ялгаатай боловч уг дэд бүтээврийн үндсэн шинж, утгыг агуулсан нэрээр тодорхойлжээ. Монгол хэлний дэд бүтээврийг тусгайлан судалсан бүтээл ховор бөгөөд энэ тухай өөрсдийн санал дүгнэлтийг М.Базаррагчаа, Ш.Туяа, Б.Идэрбаяр, оросын монголч эрдэмтэн Г.Ц.Пюрбеев нарын эрдэмтэд дэвшүүлсэн байдаг.

Оросын эрдэмтэн В.Г.Чурганова¹ 1967 онд хэвлүүлсэн нэгэн өгүүлэлдээ дэд

¹ В.Г.Чурганова “О предмете и понятиях фонемологии” (Известия АН СССР .Серия литературы и языка.4.1967.стр.366-367)

бүтээврийн шинжтэй хэлний үзэгдлийг “бүтээвэр-авиалбар зүйн ялгаварт хэсэг” гэж нэрлэжээ. Тэрээр “Сүүлийн үед дэд бүтээврийг үгийн хэлбэрийн бүтээвэр-авиалбар зүйн ялгаварт хэсэг (морфонологический релевантные отрезки слов) гэж үзэж байна. Жишээ нь: *зубец, чепец* гэх мэт үгийн *-ец, -ц* гэсэн багасгасан утгатай дэд бүтээврийг авч *зубчик, чепчик* (бяцхан шүд, бяцхан оройвч) гэсэн үгсийг бүтээж байна” гэжээ.

Орос хэлний бүтээвэр судлаач Е.А Земская² “Авианы бүтцээр ба янз бүрийн сэлгэцээр тухайн бүтээврээс ялгарч байвч утгын ялгаа гаргахгүй байгаа тийм хэсгийг дэд бүтээвэр (субморф) гэнэ. Дэд бүтээврийг өгүүлбэрийн бүтцээс ялгах нь чухал. Учир нь дэд бүтээвэр нь үг бүтэх ёсонд (словообразовательное поведение) нөлөөлдөг” гээд *ларь-ларец, сын-сынок*, нож-ножик гэх мэт үгэнд орсон *-ец, -ок, -ик* гэсэн дагавруудаар жишээ авсан байна. Харин *чепец-чепчик, чулок-чулочек, колпак-колпачок* зэрэг үгсэд орсон *-ик, -ок* дагаврыг үндэс бүтээхэд оролцож байгаа дэд бүтээвэр хэмээн ялгажээ.

Д.С Ворт³ Олон улсын хуралд тавьсан нэгэн илтгэлдээ: “Бидний бодоход одоогийн бүтээврийн бүтэх хэсэгт олон ойлголт багтдаг. Үүнд: бүтээврийн хэсгүүд, авиалбар зүйн хэлбэртэй байх, утгын агуулгагүй бүтээвэр гэх мэт” гэжээ. Эдгээрээс “Утгын агуулгагүй бүтээвэр” гэдэг нь дэд бүтээврийн тухай дурджээ.

Дэд бүтээврийн тухай Оросын эрдэмтэд судалгааны ном, бүтээлүүддээ дээрх маягаар үзсэн бол О.С.Ахмановагийн тайлбар толийн 460-р талд: “*Субморфемный*” (анг.submorphemic) гэсэн үгийг “Не дифференцированный на уровне морфем” буюу “бүтээврийн түвшинд утга үл ялгах бүтээвэр”⁴ хэмээн тайлбарласан байна.

Монгол хэлэн дэх дэд бүтээврийг тусгайлан судалсан судалгаа ховор бөгөөд М.Базаррагчаа, Ш.Туяа, Б.Идэрбаяр, Оросын нэрт монгол судлаач Г.Ц. Пюрбеев зэрэг судлаачид өөрсдийн бүтээлүүддээ дараах байдлаар дурджээ.

Эрдэмтэн М.Базаррагчаа монгол хэлний гарал судлалын тухай “Га...хэмээх үе-утгалбар” өгүүлэлдээ га... үе-утгалбарын хийсвэр шинжийг тоочжээ.

Мөн судлаач Ш.Туяа⁵ “Хэлбэрээрээ бүтээвэртэй адил боловч бүтээвэр биш үүсмэл үгийн хэсгүүдийг хуурмаг бүтээвэр (квазиморфемы) буюу гол бус бүтээвэр (субморфемы) гэж нэрлэх нь бий” гээд суб-аренда, нем-ец зэрэг жишээг дурджээ.

2. Оруулбарын аргаар монгол хэлний үг бүтэх нь

Монгол хэлний үг бүтэх ёсны үндсэн ойлголтуудын нэг бол үг бүтэх арга юм. Үг бүтэх аргыг дотор нь нийтлэг шинжээр нь үг бүтэх үндсэн арга, туслах арга гэж хуваан үзэж болно. Үг бүтэх үндсэн аргад дагаврын арга, үг нийлэх арга багтах бөгөөд эдгээр нь монгол хэлний үгийн сан баяжих хамгийн түгээмэл, гол арга зам юм. Монгол хэлний үг бүтэх эдгээр аргаас оруулбарын аргаар үг бүтэх арга нь дэд бүтээврийн илрэх хэлбэртэй холбогдож байгаа юм. Тухайлбал: ноор/н/хой, цоор/н/хой, шив/г/нэх, ич/г/үүр, таглаа/с/тай, чигжээ/с/тэй, баглаа/с/тай гэх мэт үгэнд буй -н, -лд, -с, -г бүтээврүүд нь тухайн үгэнд нэмэгдсэн ч утгын ялгамжаа төдий л

² Е.А.Земская “Современный русский язык”, М.,стр.81-82

³ Д.С.Ворт “Морфология славянского словообразования”, American contributions to the VII International congress of Slavists I.The Hague, 1973., p.387.

⁴ О.С.Ахманова “Словарь лингвистических терминов”, М., 1969, стр.460.

⁵ Ш.Туяа “Үг бүтэхүйн утга зүй”, Уб., 2005, 28 тал.

гаргахгүй байгаа учир оруулбар шинжтэй дэд бүтээвэр гэж үзэж байна.

Харин монгол хэлэнд оруулбар бүтээвэр бий эсэх талаар эрдэмтдийн санал зөрүүтэй байдаг ч дараах эрдэмтэд монгол хэл болон түүний төрөл бусад хэлэнд оруулбар бүтээвэр байдаг талаар өөрсдийн саналыг дэвшүүлсэн байдаг.

Т.А.Бертагаев оруулбарын талаар дурдахдаа “Монгол хэлний дуньсан, баоань аялгуунд оруулбар байдаг гээд *хулан-хулуулаган (улаан-маш улаан), шыра-шыпураган (шар-шав шар)* гэхэд “-ну” оруулбар нь хүч нэмэгдүүлсэн утгатай байгаа бол баоань хэлэн дэх *фелан-фабалган (улаан-улаавтар),шира-шибэрги (хар-харавтар)* гэхэд “-ба” оруулбар нь багасгасан утга илэрхийлж байна” гэжээ.

Мөн доктор, профессор М.Базаррагчаа⁶ “«Б» хэмээх оруулбар утгалбар нь утгвар бүтээврийн бүрэлдэхүүнд багтсан нь” өгүүлэлдээ “Монгол хэлнээ CV гэсэн язгуур ка-ка-(хахах), кө-кү-(хөхөх), кө-ки-(баясах), ко-ку-ий-(хохойх), ку-ка/у-ий-(хухайх), кэ-кэ-ий-(хэхийх-ихэмсэглэх) гэх мэтээр давтан үг бүтээдэг. Энэхүү давтамал язгуурын завсар “б, г(э), р, л, м, н, (нг)” гийгүүлэгч буюу авиа-утгалбар шурган орж, нэлээд өөр утга бүхий үг бий болдог” хэмээн монгол хэлэнд оруулбарын аргаар үг бүтсэн жишээг дурьджээ. Үүнд: ховх, хавх, хав, хаван, хөвх (хөндий, ухмал газар) Цааш нь “орүүлбар “б” утгалбар нь өнгө зүс заасан үгсийн язгуурыг давтахдаа хоосон зайг алгасан “у-б у-ла-га-н” (ув улаан), “кө-б кө-кэ” (хөв хөх) гэхчлэн утгварын үүрэг гүйцэтгэнэ” гэжээ.

3. Б.Ринчений “Үүрийн туяа” роман дахь дэд бүтээвэр, түүний найруулгын үүрэг

Их зохиолч Б.Ринчений “Үүрийн туяа” роман бол Монголын орчин үеийн уран зохиолын сор болсон бүтээлүүдийн нэг бөгөөд түүх, хувьсгалын сэдэвтэй, хэл найруулга, үг хэллэгийг урнаар ашиглан найруулгын өндөр түвшинд бичигдсэн зохиол болно.

Уг роман дахь дэд бүтээвэр бүхий үгсийг шүүн үзэхэд ачаастай, баглаастай, бичээстэй, бөглөөстэй, бүрээстэй, дүрс, дүүжлээстэй, золиос, өлгөөстэй, өрөөстэй, сөхөөстэй, татлаастай, чанаастай, хавчуулаастай, хадгалаастай, үйлс, хүлээстэй, хэрээстэй, шулмас, зүдрэх, бүгдээр, цайвгар, амьдралгатай, даруулга, тойруулга, бодлого, дамнуурга, ичгүүр, тэвээрэг, цулгай, шивээнэх, шургуулга, барилдлагаатай, аливаа, аргамжаа, төсөө, гудамж, далдуур, зүсэм, инээдэм, ором, манаач, сүүлч, тагнуулчин, тонуулчин, хулгайч, хонжоо, тохиолдох, тааралдах гэх мэт 48 үг давхардсан тоогоор 255 удаа давтагдан оржээ.

Эдгээр дэд бүтээвэр бүхий үгсийг дэд бүтээвэргүй хувилбар буюу утгын хувьд ихэд зөрөөгүй, ижил утга илтгэж байгаа нөгөө үгтэй нь харьцуулан шүүхэд дараах үгс хоёр хувилбараар зохиолд хэрэглэгджээ. Үүнд: ачаатай-ачаастай, баглаатай-баглаастай, дүр-дүрс, золио-золиос, үйл-үйлс, шулам-шулмас, зүдэх-зүдрэх, эдгэх-эдгэрэх, бүгд-бүгдээр, дамнуур-дамнуурга, бодол-бодлого, ичүүр-ичгүүр, тэвээр-тэвээрэг, цул-цулгай, шивнэх-шивээнэх, алив-аливаа, аргамж-аргамжаа, төс-төсөө, гудам-гудамж, далд-далдуур, зүс-зүсэм, инээд-инээдэм, ор-ором, манаа-манаач, сүүл-сүүлч, тонуул-тонуулчин, тагнуул-тагнуулчин, хулгай-хулгайч, хожоо-хонжоо, тохиох-тохиолдох, таарах-тааралдах гэх мэтээр 31 үг нь дэд бүтээвэртэй,

⁶ “МУИС-ийн МСС-ийн эрдэм шинжилгээний бичиг” XIV боть.1999.5-р дэвтэр (36-39)

бүтээвэргүй хоёр хувилбараар романд орсон бөгөөд давхардсан тоогоор 493 удаа байна. Эдгээрээс хамгийн их хэрэглэгдсэн үгс нь бодол-бодлого, бүгд-бүгдээр, хулгай-хулгайч, гудам-гудамж байна. Хамгийн цөөн хэрэглэгдсэн буюу тус бүр 1 удаа орсон нь бөглөөтэй-бөглөөстэй, золио-золиос, зүдэх-зүдрэх, таарах-тааралдах, шулам-шуламс гэсэн үгс байна.

Дэд бүтээврийг илрэх хэлбэрийн хувьд авч үзвэл –га⁴, –с, –р, –ээр, –аа⁴, –ж, –уур, –м, –ч (чин), –н, –лд, –ц, –д гэсэн 13 дагавар болон оруулбар бүтээврүүдээр илэрч байна. Үгийн тархцаар –га⁴, –с дэд бүтээвэрт хамаарах үгс хамгийн их байна.

Дэд бүтээвэр бүхий үгсийг утгын хувьд авч үзвэл, найруулга хэрэглээний бага зэрэг ялгаа үүсгэж байгаа бөгөөд голдуу үйлийн үр дүн, эзэн, явц, хэрэглүүр, багаж хэрэгслийн утга заасан нэр үүсэж байна. Жишээ нь: дүр-дүрс, золио-золиос, үйл-үйлс, дамнуур-дамнуурга, бодол-бодлого, аргамж-аргамжаа, тонуул-тонуулчин, тагнуул-тагнуулчин, хулгай-хулгайч гэх мэт.

Оруулбарын аргаар дэд бүтээвэр илрэх нь голдуу нэр, шинж тэмдэг, үйл заасан үгсэд тохиолдоно. Жишээ нь: шив/г/нэх, эдгэ/р/х, цоор/н/хой, ноор/н/хой. Мөн энэ аргаар илрэх нэг хэлбэр нь харьцангуй тэмдэг нэр бүтээх үед дэд бүтээвэр тохиолдож байна. Жишээ нь: татаа/с/тай, өлгөө/с/тэй, бичээ/с/тэй, овоолоо/с/той, дүүжлээ/с/тэй.

“Үүрийн туяа” романд хэрэглэгдсэн дэд бүтээвэртэй, дэд бүтээвэргүй үгийг утгаар нь харьцуулбал тухайн хоёр үг нь утгын ялгаагүй буюу тухайн хоёр нөхцөлд нэг утга илтгэж байгаа үгс, найруулгын хувьд маш бага утга ялгаж байгаа дараагийн бүлэг үгс, утгын ялгаа их байгаа гутгаар бүлэг үгс гэж ялгаж болохоор байна.

Нэг. Утга ялгахгүй байгаа дэд бүтээвэр бүхий жишээ

1. “Ардын хүзүүн дээр зайдалж мордоод мөлжиж байдгийг бүр мөсөн хөөж, ард амьтныг хүн шиг **амьдралгатай** болгохын арга зам ер байдаг бол уу?” (Б.Р, Уб, 1993, 141 тал) гэсэн жишээ болон “Тэндээс Ширчин, дайн байлдааны түгшүүрт цэргийн эрийн хэрэн бядаж явах **амьдралтай** болж олон удаа харьтан дайсны цусаар мялаасан, Магсаржавын дайчин тугийн дор өмнө хязгаарын туушид явж хятадын цэргийн харгис эрхтний хар цэрэг, янз бүрийн бүлэг цүлэг дээрэмчидтэй байлдан тэмцсээр, бярууны билчээрээс холдож...” (Б.Р, Уб, 1993, 304 тал) гэхэд байгаа амьдралгатай-амьдралтай гэсэн хоёр үгийг харьцуулахад хоёул “амь зуух үйл ажиллагаа” (Я.Цэвэл, 42 тал) гэсэн утгаар оржээ.
2. “Одоо үжвээс, гэнэн чагаан сэтгэлээр **алив** юмыг хэтэрхий сайнаар бодож байсан байна” (Б.Р, Уб, 1993, 274 тал) болон “Богдын зарлигаар **аливаа** хэргийг ерөнхийлөн шийтгэх түр засгийн газар болж, эрхийг баривал зохино” (Б.Р, Уб, 1993, 178 тал) гэхэд байгаа алив-аливаа гэсэн үгс нь “хамаг” (Я.Цэвэл, 39 тал) гэсэн утгаар оржээ.
3. “Гэвч миний бодоход баян хүний гадаа **аргамжаатай** морь шиг, төрлийн хэлхээгээр аргамжаатай ураг төрлийн хүнээс огт хамаагүй, явъя гэсэн цагтаа явчих, хөндлөнгийн ядуу хүн дээр дэг ээ гэж ярилцсаар зангийнд

- хүрвээс...” (Б.Р, Уб, 1993, 149 тал) болон “Чөлөө олодохгүй гэж, чи **аргамжтай** морь болсон юм уу?” (Б.Р, Уб, 1993, 204 тал) гэхэд байгаа аргамж-аргамжаа гэсэн үгс нь “морь малыг татах урт сур, оосор” (Я.Цэвэл, 50 тал) гэсэн утгаар оржээ.
4. “Чийрэг банди, суугаа чигээрээ, Цэрэнгийн зүг эргээд, айн бишүүрхэж уйлан бархирсан Төмөрийг бянтай гараараа цааш нь түлхээд, хонь шиг, дөрвөн мөч **баглаастай** атиран хэвтэж байгаа Цэрэнг татаж эргүүлээд, хүлээсийг яаралгүй тайллаа” (Б.Р, Уб, 1993, 375 тал) болон “Цагаан эргээр цувж яваа машины өөдөөс, **баглаатай** ноос, арьс шир, зээр гахайн мах, бас брезентэн бүтээлгийн дор чухам юу байгаа нь мэдэгдэхгүй...” (Б.Р, Уб, 1993, 596 тал) гэхэд байгаа баглаатай-баглаастай гэсэн үгс нь “хэсэглэн багласан байдал” гэсэн утгаар оржээ.
 5. “Эгчмэд хүүхэд, **бодлого** болсон эхийн зүг харж асууруун” (Б.Р, Уб, 1993, 9 тал) болон “**Бодол** болж суугаа нь, монгол хүн жар хүрээд ухаан орж, жаран нэгэндээ үхдэг гэж Бизъяагийн ламын хэлсэн үг санаанд нь орж, би төвөд эцэг эхтэй боловч...” (Б.Р, Уб, 1993, 428 тал) гэхэд орсон “хүний ухаандаа сэтгэх, эргэцүүлэх” (Я.Цэвэл, 87 тал) гэсэн утгаар оржээ.
 6. “Хол газар явж, сонин сайхан юм үзнэ гэж бид **бүгд** маш баярлаж байна” (Б.Р, Уб, 1993, 528 тал) болон “Хаан харц, хамаг **бүгдээр** дагадаг эртний эрхэм нэгэн ёс бий” (Б.Р, Уб, 1993, 409 тал) гэхэд байгаа бүгд-бүгдээр гэсэн үгс нь “цөм, бүгд, бүхэн” (Я.Цэвэл, 114 тал) гэсэн утгаар оржээ.
 7. “Хүрээний зүгээс төрийн жагсаалаар явж яваа хүн үзэгдэж, эхэнд нь хоёр морьтой хүн жагсаалыг удирдаж, тэдний хойноос найман чийрэг эр улаан арал **дамнууртай** тугалган жинст, ногоон өнгийн хөшиг дээвэрт сүүх дамнажээ” (Б.Р, Уб, 1993, 256 тал) болон “Бараа бологч нар машинаас яаран гарч, генералын тэрэгний хаалгыг нээж, хятад офицерууд, цагаан хуйтай урт сэлмийг газар чирэн цувж автогоор авчирсан, торгоор ороон чимсэн **дамнуурга** дээр ерөнхийлөгчийн том зураг залаад, гуулин бүрээ үлээх, хэнгэрэг цохих их дуу шуу болж **дамнуургыг** дамнан их хаалганы зүг давшин алхлав” (Б.Р, Уб, 1993, 342 тал) гэхэд байгаа дамнуур-дамнуурга гэсэн үгс нь “юмыг дамнан явахад хэрэглэх хэрэгсэл” (Я.Цэвэл, 196 тал) гэсэн утгаар оржээ.
 8. “Тэрнийг бодоход баахан айдас хүрэх байна гэж хэлээд, нэгэн ядуу үйлчин эмгэн олноос **ичүүрсхийн**, нүүрээ дээлийн ханцуйгаар бөглөвөөс, өвгөн Чамбай...” (Б.Р, Уб, 1993, 538 тал) болон “Чи тэдний хоньчин хүү, чамайг өргөсөн Жамба, Жантайтай суугаад хөөж орхисон юм биш үү, чамайг? хэмээвээс, Ширчин баахан **ичгүүрсхийв**” (Б.Р, Уб, 1993, 149 тал) гэхэд байгаа ичүүрсхийн-ичгүүрсхийв гэсэн үгс нь “ичих үйлийн нэр” (Я.Цэвэл, 311 тал) гэсэн утгаар оржээ.
 9. “Эцэнгэр хүрэн биед нь зодуулж нүдүүлсний **ор** хөх няц үзэгдэн, толгойд нь энд тэнд булдруутсаныг үзвэл, оргож босохын өмнө ч их л зодуулсан байдал илэрхий” (Б.Р, Уб, 1993, 391 тал) болон “Тансаг, хүүгийн ясан дээр ирээд, тэмээнээс гулган бууж, аяархан, хүүгийн толгойн өмнө сөгдөж, тэр хатуу харгис сэтгэлтэй ламын зодуурын **ором** сорви, овгор товгоры нь

өвдүүзэй гэсэн адил, гараараа зөөлхөн гэгчээр илэн барьж үзээд...” (Б.Р, Уб, 1993, 400 тал) гэхэд байгаа ор-ором гэсэн үгс нь “ичих үйлийн нэр” (Я.Цэвэл, 311 тал) гэсэн утгаар оржээ.

10. “Цагаагчин гахай жилийн намрын **сүүлээр** Ширчингийн ахыг Хөлтгөний хөндийд намаржаад байх үес, Ширчин, хээр хонь хариулж байгаад, нэгэн өдөр үзвээс, олон тэмээтэй аянчин ажиглалал, Соном зангийн авгай явалцжээ” болон “Өвлийн дунд сарын **сүүлчээр** шуурга хөдөлжээ” гэхэд байгаа сүүлээр-сүүлчээр гэсэн үгс нь “алив юмын хойд, адаг, бөгс” (Я.Цэвэл, 498 тал) гэсэн утгаар оржээ.
11. “Синин хотод Самданжамба гэдэг, далаад хүнтэй уулзаж сонсвол төвөд газар монгол үгээр хэлэлцдэг шар уйгар, мөн Синьзяны уйгартай **төсөөтэй** үгээр хэлэлцдэг хар уйгар гэж байдаг юм гэж сонссон” (Б.Р, Уб, 1993, 30 тал) болон “За, Батбаяр гуай энэ бол уйгар үсэг танай монгол үсэгтэй нэлээд **төстэй** биз? Энэ хятад үсэг” (Б.Р, Уб, 1993, 31 тал) гэхэд байгаа төс-төсөө гэсэн үгс нь “байдал, маяг ойролцоо” (Я.Цэвэл, 552 тал) гэсэн утгаар оржээ.

Хоёр. Найруулгын хувьд маш бага утга ялгаж байгаа дэд бүтээвэр бүхий жишээ

1. “Харин энэ танигдахгүй, хятад байшинд яагаад орчихлоо гэж байгаа байшин бол, хөл үймээн багатай Юн Хо гүнгийн **гудам** дахь буурчийн байшин бөгөөд зүүд биш, ёстой үнэн байдал ажээ” (Б.Р, Уб, 1993, 83 тал) болон “Манж хааны нийслэлд хүрч ирэхийн өмнө хэчнээн олон хошуу, гацаа хүй, их бага хот дамжсан билээ гэж бодоод, Чуулалт хаалга гэдэг хотонд анх хүрч ирээд, нутагтаа Улиастай хотод танилцсан Жан овогт мужаантай **гудамжинд** уулзсанаа санажээ” (Б.Р, Уб, 1993, 83 тал) гэхэд байгаа гудам-гудамж гэсэн үгс нь “эгнэсэн хашаа, байшин, түүний доторх завсрын шулуун чөлөө” (Я.Цэвэл, 186 тал) гэсэн утгаар орсон боловч гудам нь арай ерөнхий, тодорхой бус утгатай байхад гудамж нь “Жан овогт мужаантай гудамж” хэмээн тодорхой утгыг зааж буйгаараа найруулгын хувьд утгын ялгаа бага зэрэг гаргаж байна.
2. “Юу ч **далд** хийсэнгүй гэжээ” (Б.Р, Уб, 1993, 49 тал) болон “Да хүрээний манж ноёд амбас, та бүхэнд юм битгий зааж өг гэж **далдуур** тушаажээ” (Б.Р, Уб, 1993, 31 тал) гэхэд байгаа далд-далдуур гэсэн үгс нь “илийн эсрэг, нууц” (Я.Цэвэл, 184 тал) гэсэн утгаар орсон боловч далд гэсэн үгийн хэрэглээг авч үзвэл хийх, орох гэсэн үйл үгстэй хамт хэрэглэгдэж байна.
3. “Ховдын амбан, Магсаржавыг оргон боссоноос хойш монголчууд гэнэт халдаж болзошгүй гэж Сангийн хот гэдэг цайзын тойрон дахь гууг гүн болгож, хэрмийг сэлбэн засаад цайзанд суух дарангуй цэргийн хүчнийг зузаатган, дөрвөн зүг, найман зовхист харуул **манаа** гаргажээ” (Б.Р, Уб, 1993, 281 тал) болон “Аав гайхаж дээ хар үүрээр тэр лүү чиглэдэг ямар лам билээ гэж дотроо бодсоор, ордны ойр очоод, харц хүний мориноос буудаг газар хүрээд, морио хантайран тушиж хаалганд дөхтөл, ер хүн амьтан боссон чимээ шинж алга, хаалганы **манаач** үзэгдэхгүй шиг, тэгэхэд нь, ноёд

язгууртан хүртэл Богдод бараалхахдаа эмээн ордог тэр хаалга аюумшиггүй тогших зүрх хүрсэнгүй” (Б.Р, Уб, 1993, 566 тал) гэхэд байгаа манаа-манаач гэсэн үгсийг харьцуулахад манаа нь ерөнхий, манаач тодорхой утгыг зааж байгаа бөгөөд харуул манаа гэж хоршиж хэрэглэгдэж байгаа нь их байна. Харин манаач гэвэл хаалганы манаач, тогооч манаач хоёр гэх мэтээр утга илүү тодорч байна. Үүнтэй адил жишээ тагнуул-тагнуулчин, хулгай-хулгайч, тонуул-тонуулчин гэсэн үгс дээр мөн илэрлээ.

4. “Онц чухал явдал **тохиож**, улсын дээд ба доод хурлыг би зарлан хуралдуулав” (Б.Р, Уб, 1993, 334 тал) болон “Тэгээд миний охиныг бас, тийм гай зовлон **тохиолдуузай** гэж захихад нь, сэтгэл зовж, бүлх залгисан шиг болж байна хэмээвээс, өвгөн Чамбай унтууцаж...” (Б.Р, Уб, 1993, 437 тал) гэхэд байгаа тохиох-тохиолдох үгсийн жишээг харьцуулан харахад тохиох мөн хүндэтгэлийн, дээд найруулгад ерөнхий утгаар, тохиолдох гэсэн үг нь ерийн найруулгад тодорхой утгаар хэрэглэгдэж байгаа ялгаа харагдаж байна. Хэрэглэгдсэн хэмжээний хувьд авч үзвэл тохио- язгуурт нийт 31 үг давтагдан орсноос тохиолд- нь 29, тохио- нь 2 удаа оржээ.

Гурав. Найруулгын хувьд утгын ялгаа гаргаж байгаа дэд бүтээвэр бүхий жишээ

“Зүс царай, хүзүү, гар нь хөв хөх өнгөтэй болж, нүдний нь цагаан улайжээ” (Б.Р, Уб, 1993, 542 тал) болон “Жантай, хүү бэр хоёргоо өмч тасалж, малы нь **зүсэм** зүсмээр зааж гүйцээд сурган өгүүлрүүн...” (Б.Р, Уб, 1993, 554 тал) гэхэд зүс-зүсэм гэсэн үг нь “хүн ба амьтны нүүрний өнгө, дүр” (Я.Цэвэл, 291 тал) гэсэн утгаар орсон боловч зүс нь хүний дүрийг, зүсэм нь амьтны дүрийг заадгаараа ялгарч байна.

ДҮГНЭЛТ

Гадаад хэлбэрээрээ үгийн нэгэн утгат хэсэг буюу бүтээвэр болон харагдах боловч үнэндээ утга үл ялгах, эсвэл маш бага утга ялган найруулга, хэрэглээнд тодорхой үүрэг гүйцэтгэх, нэмэлт бүтээвэр шинжтэй, үгийн хувилбар үүсгэж байгаа тийм хэсгийг дэд бүтээвэр хэмээн тодорхойлж болно.

Уг өгүүлэлд Б.Ринчений “Үүрийн туяа” роман дахь дэд бүтээврийн илрэх хэлбэр, хэмжээ, найруулгын үүргийг жишээ баримтаар тайлбарлалаа. Уг роман дахь дэд бүтээвэр бүхий үгсийг шүүн үзэхэд ачаастай, баглаастай, бичээстэй, бөглөөстэй, бүрээстэй, дүрс, дүүжлээстэй, золиос, өлгөөстэй, өрөөстэй, сөхөөстэй, татлаастай, чанаастай, хавчуулаастай, хадгалаастай, гудамж, дамнуурга гэх мэт 48 үг давхардсан тоогоор 255 удаа давтагдан оржээ. Дэд бүтээвэртэй, бүтээвэргүй хоёр хувилбараар романд орсон 31 байгаа бөгөөд давхардсан тоогоор 493 удаа байна. Эдгээрээс хамгийн их хэрэглэгдсэн үгс нь бодол-бодлого, бүгд-бүгдээр, хулгай-хулгайч, гудам-гудамж байна. Хамгийн цөөн хэрэглэгдсэн буюу тус бүр 1 удаа орсон нь бөглөөтэй-бөглөөстэй, золио-золиос, зүдэх-зүдрэх, таарах-тааралдах, шулам-шуламс гэсэн үгс байна.

Дэд бүтээврийг илрэх хэлбэрийн хувьд авч үзвэл –га⁴, –с, –р, –ээр, –аа⁴, –ж, –уур, –м, –ч (чин), –н, –лд, –ц, –д гэсэн 13 дагавар болон оруулбар бүтээврүүдээр илэрч байна. Үгийн тархцаар –га⁴, –с дэд бүтээвэрт хамаарах үгс хамгийн их байна.

“Үүрийн туяа” романд хэрэглэгдсэн дэд бүтээвэртэй, дэд бүтээвэргүй үгийг утгаар нь харьцуулбал тухайн хоёр үг нь утгын ялгаагүй буюу тухайн хоёр нөхцөлд нэг утга илтгэж байгаа үгс, найруулгын хувьд маш бага утга ялгаж байгаа дараагийн бүлэг үгс, утгын ялгаа их байгаа гутгаар бүлэг үгс гэж ялгаж болохоор байна.

НОМ ЗҮЙ

1. Ахманова О.С. “Словарь лингвистических терминов”, М., 1969.
2. Бадамдорж Д. “Монгол хэлний утга судлал”, Уб., 2001, 1-р дэвтэр МУИС-МСДС, ЭШБ №13 (139), Уб., 1998.
3. Базаррагчаа М. “«Б» хэмээх оруулбар утгалбар нь утгвар бүтээврийн бүрэлдэхүүнд багтсан нь” МУИС, ЭШБ, XIV боть, (V дэвтэр), Уб., 1999.
4. Базаррагчаа М. “Утгын чуулган”, Уб., 2002.
5. Бертагаев Т.А. “Морфологическая структура слова в монгольских языках”, М., 1972.
6. Бэшэ Л. “Монгол хэлний үйл үгийн утварын тухай”, *Studia Mongolica*. Tom VI, Fasc 12.
7. Бямбасан П. “Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгийн аймаг”, Уб., 1975.
8. Ворт Д.С. “Морфонология славянского словообразование”, *American Contributions to the VI International congress of slavists, I. The Hague.*, 1973.
9. Земская Е.А. “Современный русский язык”, М., 1973.
10. Идэрбаяр Б. “Монгол хэлний төсөөт үг”, Уб., 2005.
11. Кубрякова Е.С. “О типах морфологической членимости слов, Она же. Основы морфологического анализа”, М., 1974.
12. Лопатин В.В. “Русская словообразовательная морфемика проблемы и принципы описания”, М., 1977.
13. Ринчен Б. “Үүрийн туяа” роман, Уб, 1993.
14. Моисеев.А.И “Основные вопросы словообразования в современном русском литературном языке”.
15. Өнөрбаян Ц. “Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс”, Уб., 2000.
16. Пюрбеев Г.Ц. “Об одном типе синонимов в современной монгольской терминологий”, ШУА, ХЗХ, “Нэр томъёо судлал” №8, Уб., 2006.
17. Туяа Ш. “Үг бүтэхүйн утга зүй”, Уб., 2005.
18. Цэвэл Я. “Монгол хэлний товч тайлбар толь”, Уб., 1966.
19. Чурганова В.Г “О предмете понятия фонеморфологий” («Известия АН СССР. Серия литературы и языка» вып.4), М., 1964.
20. Шанский Н.М “Исследования по современному русскому языку” (Издательство Московского университета), М., 1970.

SUMMARY

**The stylistics function and feature of the sub morphs in novel
“The Uuriin Tuya” by B.Rinchen**

There are many methods for forming new words in the contemporary Mongolian language and one of them is word formation by suffixes. New word is formed with connected suffix to its root. However, the exciting phenomenon that new word has no semantic meanings is emerged when suffix connected to word roots. In morphology, it is called sub morph.

In the scope of this paper, we considered that sub morph, especially focused on the sub morph in novel “Uuriin tuya” by B.Rinchen. We compared with words which has sub morph and studied their usage. At the result of this survey, almost 48 words such as damnuur-damnuurga, baglaatai-baglaastai,, gudam-gudamj, zolio-zolios, bodol-bodlogo and bugd-bugdeer are same to each other in view of stylistics usage.